

ТАНИЛЦУУЛГА

Согтууруулах ундааны хариуцлагатай
үйлчилгээний сургалтын
шинэчилсэн журмын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна.

Уг хуульд “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан”-ийн талаар шинэ зохицуулалт тусгагдсан бөгөөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулж, Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санг байгуулсан. Тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний нэг нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт бөгөөд энэ төрлийн сургалтад согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчлэх үүрэг бүхий ажилтан хамрагдах юм.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байна.” гэж, 25.2-т “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт нь хууль тогтоомжийг таниулах, үйлчлүүлэгчийн насыг тогтоох, үйлчлүүлэгч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилыг төлөвшүүлэх зорилготой байна.” гэж, мөн 25.4-т “Энэ хуулийн 25.2-т заасан хариуцлагатай үйлчилгээ явуулах журам, хариуцлагатай үйлчилгээний жишиг төлбөрийн хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж тус тус заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Журам болон жишиг төлбөрийн хэмжээ батлах тухай” 2023 оны А/04 дүгээр тушаалаар холбогдох журам, жишиг төлбөрийн хэмжээг баталсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор тус сангийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг, Засгийн газрын 2024 оны 149 дүгээр тогтоолоор сангийн дүрэм, сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”-ыг шинэчлэн батлах шаардлагатай болсон тул уг журмын төслийг шинэчлэн боловсрууллаа.

Сургалтын журмын төсөл шинэчлэн батлагдсанаар согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт зохион байгуулах хуулийн этгээдийн эрх үүрэг, санхүүжилт олгох асуудал тодорхой болж, сургалтын чанар, үр дүн дээшлэх ач холбогдолтой гэж үзлээ.

---oOo---